

History of the XX Century Mongolia

**1921 REVOLUTION: 5. GOLDEN CLAN OF CHINGGIS KHAN – RE-
PROCLAMATION OF INDEPENDENCE**

LECTURE 9

LECTURER: PROF. OTGONJARGAL SODNOMDARJAA
NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA



XX зууны Монголын Түүх

1921 ОНЫ ХУВЬСГАЛ: 5. ЧИНГИС ХААНЫ АЛТАН УРАГ –
ТУСГААР ТОГТНОЛОО СЭРГЭЭН ТУНХАГЛАСАН НЬ

ЛЕКЦ 9

ПРОФ.ОТГОНЖАРГАЛ СОДНОМДАРЖАА
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ



Лекцийн агуулга

Чингис хааны үр удам болсон Алтан ургийнхан тусгаар тогтнолоо байлдан олсон үнэн түүх нь оюун ухаант хүчтэнгүүд түүхийн хүрдийг эргүүлдэг гэсэн зүй тогтлыг нотлож байгааг энэхүү лекцээс мэдэж авна



Богд хаан нараас Орос улсад тусламж гуйж нугалбар бичгээ явуулсан боловч хариу ирэлгүй 6 сарын хугацаа өнгөрч Орос улс туслах эсэх нь эргэлзээтэй болсон үед Ноёдын намаас өөрсдөө тусгаар тогтнолоо олж авах шийдвэр гаргав.



Барон Унгернтэй холбоо
тогтоох даалгаврыг
Түшээт хан аймгийн
Дархан чин вангийн
хошууны тэргүүн зэрэг
тайж Лувсанцэвээнд өгчээ.
Энэ үед Барон Унгерний
цэрэг Сэцэн хан аймагт
орж ирсэн байлаа



<https://www.mn.wikipedia.org>

Тэргүүн зэрэг тайж, Жанжин Лувсанцэвээн



Жанжин Лувсанцэвээнийг цагаантны
хүчтэй холбоо тогтоосныг мэдсэн хятадын
эрх баригчид Богд хааныг шадар
сайдуудынх нь хамт баривчилж, Богд
хааныг Хятад яамны дэргэдэх нэгэн
байшинд хорив



Монголын цэргийн жанжин Лувсанцэвээн Хүрээ рүү цэрэг хөдөлгөхийн өмнө Богд хааныг нууцаар суллан авах ажиллагааг зохион байгуулж хамгийн шаламгай 70 гаруй эрсийг шилэн сонгож Богд хааныг оргуулан авах даалгавар өгчээ.



<https://www.mn.wikipedia.org>



Лувсанцэвээний шилдэг цэргүүд Богд хааны буй газар луу довтлоход хятадын олонхи цэргүүд Орос, Монголын цэрэг орж ирж байна хэмээн андуурч хэсэг зуур зугтсан хойгуур Богдыг харгалзан хянаж байсан олон хятад цэргүүдтэй монгол цэргүүд эрэлхэгээр байлдаж Богд хаан, Эх дагина хоёроо суллан авчээ



Хятадын удирдлагууд Богд хааныг алдсаныг мэдэж байдал хүндэрч байгааг ухаарч ихэд балмагдаж байсан үед Орос, Монгол нийлсэн 13 мянган цэрэг Хүрээг довтлох гэж байгаа тухай цуу мэдээг монгол цэргийн хуарангаас тараав



Монголчууд XX зууны эхэнд, зурагт түүх, Монсудар, 2011,141



Нийслэл хүрээг
чөлөөлөхийн өмнө
Барон Унгерн
Монголын цэргүүдийг
урдаа түлхэж оруулах
зорилгоор гүн
Найданжавт довтолгоо
эхэлсэн гэсэн ташаа
мэдээ хүргүүлэв



<https://www.zolord.ru>


Барон Унгерн фон Штернберг



Мэдээг авмагц гүн Найданжав Чингисийн үеийн дайн тулааны аргыг хэрэглэж Хүрхрээгийн амнаас Хүүшийн ам хүртэл модны дотор ойр ойрхон гал түлсэн нь олон цэргийн гал мэт их сүрийг үзүүлж хятадуудад сэтгэл зүйн дайралт хийсэн байна. Маргааш нь хятадын цэргүүд монгол цэргүүдийг орж ирэхэд үхэр буугаар дал шахам удаа буудсан хэдий ч сум битүүгээр унаж нэг ч сум дэлбэрээгүй юм



Үүний араас жанжин Лувсанцэвээн, Барон Унгерний цэргүүд Хүрээнд орсоноор хятад цэргийн хүчирхийллээс Хүрээг чөлөөлжээ. Хүрээг чөлөөлмөгц юуны түрүүнд ноёдын бүлгэмийн гишүүдээ суллан авчээ. Харамсалтай нь манлай баатар Дамдинсүрэн эмгэнэлтэйгээр нас барсан байв.



<https://www.eagle.mn>



Ийнхүү Хүрээг
чөлөөлөхдөө монгол
цэргүүд Монгол төрийнхөө
шар хамбан тугаа
намируулан дун бүрээгээ
татаж орж ирсэн юм.
Жанжин Лувсанцэвээн
түүний цэргүүдийг ард
түмэн сүү цайныхаа
дээжийг өргөн хүлээж авав.



Монголчууд XX зууны эхэнд зурагт түүх,
Монсудар, 2011, 144



1921 оны 2 сарын 22-нд Богд хааныгаа эргүүлэн залж засгийн
газрын таван яамдыг байгуулав



Монголчууд XX зууны эхэнд зурагт түүх, Монсудар, 2011, 146



1921.2.22-нд байгуулагдсан Засгийн газрын бүрэлдэхүүн

РГА ТУСГААР МОНГОЛ УЛС

Жалханз хутагт С.Дамдинбазар



1921 оны 2-р сараас 5-р сар хүртэл,
1922-1923 онд Монгол улсын Ерөнхий
сайдаар ажиллаж байв.

Тэргүүн тайж Лувсанцэвээн



Сангийн яамны тэргүүн сайд

Бэйс Чимэддорж



Шүүх яамны тэргүүн сайд

Монголчууд XX зууны эхэнд зурагт түүх, Монсудар, 2011, 144



1921.2.22-нд байгуулагдсан Засгийн газрын бүрэлдэхүүн

1911-1924

Шанзав Дашжав



Гадаад яамны сайд

Ван П.Доржцэрэн



Цэргийн яамны сайд

Хатанбаатар ван С.Магсаржав



Цэргийн жанжин

Монголчууд XX зууны эхэнд зурагт түүх, Монсудар, 2011, 145



Хүрээнд болж буй энэхүү улс төрийн үйл явц нь Монголоос тусламж гуйн очсон монголын төлөөлөгчдийг өөрсдийн хэтийн зорилгодоо ашиглах улаан Оросын үйл ажиллагааг идэвхижүүлжээ.



References

1. ХХ зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй, Отгонжаргал С, Адмон хэвлэлийн газар, 2003
2. Монгол улсын шинэ түүх, Магсаржав Н, Монсудар, 2010
3. Монголчууд ХХ зууны эхэнд зурагт түүх, Монсудар, 2011



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

